

## ОРОС-МОНГОЛЫН ХАРИЛЦААГ ӨРГӨЖҮҮЛЭН ХӨГЖҮҮЛЭХ АСУУДАЛД

*М.Татьяна\**

ОХУ анх 1991 онд байгуулагдаж Б.Ельцины хэлснээр “шилжилтийн эмзэг үед”<sup>1</sup> шилжин орсныхоо дараа АНУ тэргүүтэй барууны орнуудтай ойртож хамтын ажиллагаа хөгжүүлэх бодлого баримталсан боловч энэ нь эцэстээ барууныг хэт шүтсэн өрөөсгөл хандлага болж хувирсан юм. “Козыревын үеийн” гэж нэрлэгдсэн энэ бодлогын сөрөг талуудаас зохих дүгнэлт хийж 1993 онд ОХУ-ын Гадаад бодлогын үзэл баримтлалыг баталж, түүнд Ази тивийг онцгой анхаарах чиглэл тусгасан юм. ГЯЯ-ны сайдаар Е.Примаковыг томилсон үеэс ОХУ-ын Ази дахь гадаад бодлого мэдэгдэхүйц идэвхжиж эхэлсэн билээ.

Ингэж Ази дахь бодлогоо идэвхжүүлэх болсон нь хэл хэдэн учир шалтгаантай байв. Тухайлбал:

- Барууны орнуудыг хэт их баримжаалсан гадаад бодлогыг Оросын нийгэм хурцаар шүүмжлэх болсон, ялангуяа Евразийн үзэлтнүүдийн нөлөө хүчтэй болсон,

- Баруун Европын орнуудад газрын тос, шатдаг хий нийлүүлэх замаар хамтран ажилладаг хэлбэр эдийн засгийн хувьд үр өгөөж муутай төдийгүй эцсийн дүнд ОХУ түүхий эд нийлүүлэгч эдийн засагтай хоцрогдсон улс болон хувирч болзошгүй,

- Евразийн сонгомол орон болсон ОХУ эдийн засгаа өөд татахын тулд Сибирь болон Алс Дорнодынхоо /энэ хоёр бүсэд ОХУ-ын алтны-80%, алмазын-95%, нефтийн-65%, байгалийн хийн-85%, ой модны нөөцийн-67% төвлөрдөг бөгөөд нийт баялаг нь 29 трлн. ам.долл. үнэлэгддэг юм<sup>2</sup>/ асар их баялгийг ашиглах ёстой. Үүний тулд Япон, Өмнөд Солонгос, БНХАУ-тай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэх нь чухал,

- Ази, Номхон далайн бүс нутгийн улсууд эдийн засгийн интеграцчилалыг янз бүрийн түвшин, хүрээнд хөгжүүлэх замаар хөгжлийнхөө түвшинг асар богино хугацаанд эрс дээшлүүлж чадсан тул тэдний хөгжлийн загвар, туршлагыг судалж, бүс нутгийн интеграцчилалд оролцох шаардлагатай гэж үзэх болсонтой холбоотой.

Азид чиглэсэн энэхүү шинэ хандлагыг хэрэгжүүлэхдээ ОХУ өөрийн хөрш, өнө удаан жилийн найрсаг харилцаатай Монгол Улсыг геостратегийн хувьд анхаарлаасаа огтхон ч гаргасангүй. Иймээс ч хоёр орны удирдлагууд хэл хэдэн удаа уулзаж, улс төрийн харилцаа,

\*М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

хамтын ажиллагааны асуудлуудыг хэлэлцэн 1993 онд “Монгол ба ОХУ-ын хоорондын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, 2000 онд “Улаанбаатарын Тунхаглал”-д гарын үсэг зурсан билээ. Эдгээр баримт бичгүүд нь Орос–Монголын харилцааны үндсийн үндэс болсон юм.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин Монгол Улсад 2000 оны 11-р сард айлчлах үеэр “Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд танай орон онцгой байр суурь эзэлдэг” гэж мэдэгдсэн.<sup>3</sup> Мөн 2001 оны 2-р сарын 23-ны өдөр ОХУ-ын ГЯЯ-аас гаргасан “Гадаад орнуудтай соёлын талаар харилцах харилцааг хөгжүүлэх ОХУ-ын ГЯЯ-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд” гэсэн чухал баримт бичигт: “Монгол, Вьетнам, Куба зэрэг орнуудын олон тэргүүний сэхээтэн манай оронд боловсрол эзэмшиж, одоо ч гэсэн Оросын соёлыг хүндэлж байдаг бөгөөд эдгээр орнуудтай уламжлалт соёлын харилцаагаа нөхөн сэргээх бодитой арга хэмжээ авах зайлшгүй хэрэгтэй” гэж тэмдэглэсэн юм.<sup>4</sup> Энэ бүхнээс үзэхэд, Монгол Улсыг урьдын адил Оросын хувьд геостратегийн ач холбогдлоо алдаагүй байгааг илэрхийлсэн нь тодорхой.

Эдүгээ ОХУ-ын ГЯЯ нь чиглэлийн 15, чиг үүргийн 23 газартай, үүний дотор Азийн 1, 2, 3-р ба Азийн ерөнхий асуудлаархи гэсэн газруудтай юм. Азийн 1-р газар нь Хятад, БНАСАУ, Монгол, БНСУ-г хамаардаг. Үүнийг ОХУ Зүүн хойт Азийн хөрш орнуудаа тэргүүн байранд авч үзсээр байгааг харуулсан бас нэг үзүүлэлт гэж хэлж болох юм.

Мөн ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2001 оны 1-р сарын 26-ны өдөр ОХУ-ын ГЯЯ-нд хийсэн мэдэгдэлдээ: “...Азийн чиглэлийн үүрэг роль улам нэмэгдэж байна. Европ, Ази хоёрын аль нэгэнд илүү хандах нь бид нарын зүгээс буруу гэдгийг шууд хэлмээр байна. Бид нар Барууны ч, Дорнодын ч зүг рүү хэлтийх ёсгүй. Орос Улс шиг геополитикийн байршилтай их гүрний үндэсний эрх ашиг хаана ч байж болно гэдэг бодит зүйл. Энэ чиглэлийг тууштай баримтлах хэрэгтэй. Бид нар Азийн бүх хэрэгт байр сууриа бат бэхжүүлэх ёстой. Үүний тулд Ази, Номхон далайн бүсийн интеграцийн гол бүтцэд оролцоогоо идэвхжүүлэн, мөн улмаар, юуны түрүүнд, өөрийн хөрш орнуудтайгаа болон Азийн тэргүүлэх орнуудтай найрсаг харилцаа, практик хамтын ажиллагааг тууштай өргөжүүлэх нь чухал...” хэмээн онцлон тэмдэглэв.<sup>5</sup>

Орос–Монголын харилцааны түвшингээс Алс Дорнодын бүсийн улс хоорондын харилцааны байдал ихээхэн хамаарч, улмаар Орос-

Хятад, Монгол-Хятадын харилцаа, үүний үр дүнд Алс Дорнодын хил дээрх энх тайван, аюулгүй байдал хангагдах болно. Монголоос Зөвлөлтийн цэргийг гаргасны дараа Монгол Улс ОХУ-ын хувьд цэрэг-стратегийн ач холбогдлоо алдсан гэж яригддаг боловч чухамдаа тэгэж үзэх нь эртэдсэн дүгнэлт бололтой. Газар зүйн байршил, геополитикийн хүчин зүйл нь манай хоёр орны уламжлалт харилцааны үндэс байсан, байх ч болно. Монгол Улс ОХУ ба Хятад хоёрын хооронд тусгаар тогтнон оршиж уламжлалт худалдаа, соёлын харилцаагаа хөгжүүлсээр байна. ОХУ үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхлын хувьд Монгол дахь нөлөөгөө ямар нэгэн байдлаар алдахыг хэзээ ч хүсэхгүй гэдэг нь тодорхой. Хэрэв тэгэхэд хүрвэл Хятад, Япон, АНУ-ын нөлөө ихсэж, улмаар ОХУ-ын нөлөө Монголд, цаашид Алс Дорнодод буурах болно. ОХУ хилийнхээ дагуу “сайн хөршийн бүс” байгуулахыг эрмэлзсээр ирсэн бөгөөд бүх хөрш орнуудтайгаа нөхөрсөг, харилцан ашигтай, тэгш эрхийн үндсэн дээр харилцахыг эрхэм зорилго болгож байна.

Манай хоёр орны 1991 оноос эдүгээг хүртлэх харилцааг нийтэд нь авч үзвэл улс төрийн хүрээнд зарчмын чанартай гол асуудлуудыг үндсэнд нь шийдвэрлэсэн гэж дүгнэх үндэстэй. Харин эдийн засгийн хамтын ажиллагаа, худалдаа, хил орчмын болон хүмүүнлэгийн асуудлуудаар шийдлээ хүлээсэн нилээд олон асуудал байсаар байна. Тэдгээрийг цаг хугацаа алдалгүй шийдвэрлэвэл Орос-Монголын харилцааг цаашид өргөжүүлэн хөгжүүлэх улам таатай нөхцөл бүрдэх болно.

Эдийн засгийн харилцааны хүрээнд, юуны өмнө тэмдэглэхэд, 1990-ээд оны эхнээс Орос-Монголын эдийн засгийн харилцаа объектив, субъектив олон шалтгаанаас эрс багасаж зогсонги байдалд орсон юм. 1990 онд Монголоос Орос Улсад гаргасан экспортын хэмжээ 517, 5 сая ам. долл. байсан бол, 1995 онд 68,9 сая, 2001 онд 39,7 сая болтол буурч, ОХУ-аас Монголд оруулсан экспорт мөн хугацаанд 924,0 сая ам. доллараас 201,9 сая ам.доллар хүртэл багассан байна.<sup>6</sup>

Монголын гадаад худалдааны эргэлтэд 80 хүртэл хувийг эзэлж байсан ОХУ-ын худалдаа ийнхүү 14 хувь хүртлээ их хэмжээгээр буурсан нь Монголын эдийн засагт, нэн ялангуяа мал аж ахуй, газар тариалан, тэдгээрийн бүтээгдхүүнийг боловсруулдаг аж үйлдвэрийн салбарт ихээхэн хүндрэл учруулсан юм. Улмаар 1990-1994 онд Монголын ДНБ 208,6 тэрбум төгрөгөөс 170 тэрбум төгрөг хүртэл буурсан. 1990-2001 оны хооронд Орос-Монголын хамтарсан үйлдвэрүүдэд Оросын пүүсүүдийн хөрөнгө оруулалт багасч, Монголын

эдийн засагт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 10 орчим хувийг эзэлж, хөрөнгө оруулсан нийт үзүүлэлт, нэгжүүдийн тоогоор 5-р байранд орж, харин 2001 оны байдлаар тус үзүүлэлтээр 3-р байр эзлэх болжээ.<sup>7</sup>

Орос-Монголын гадаад худалдаа зогсонги байдалд орж, өсөж нэмэгдэхгүй байгаа шалтгаанууд гэвэл:

1. Монгол Улсын экспортын уламжлалт бараануудад Оросын тал гаалийн өндөр татвар тогтоосноо одоо хүртэл багасгахгүй байгаагаас үнэ нь өндөр болж, экспортлогч ба худалдан авагчдад ашиггүй болсон байна. Иймээс Монголын экспорт эрс багассан болно.

2. Нөгөө талаас, Монгол Улсад 1990-ээд оны дунд үеэс хувьчлалыг хийхдээ ихэнх тохиолдолд төрийн хяналтан дор ил тод явуулах зарчмыг зөрчсөнөөс эдийн засгийн байдал эрс доройтож, үндэсний үйлдвэрлэл уналтанд орж эдийн засгийн чадавхи нь ихээхэн хэмжээгээр доошилсон юм. Мөн арилжааны банк дампуурсан, бизнесийг дэмжих биш мөнгө хүүлэгчид болж хувирсан байна. Улсын хэмжээгээр хөдөлмөрийн чадвартай ажилгүйдлийн тоо 200 мянгал хүрч, Монголын 3 хүн тутмын 1 нь амьдралын баталгаат түвшингээс доогуур ядуу амьдрах болсон.

3. Монголд хувьчлал хийхдээ, томоохон үйлдвэрүүдийг хэт жижиглэн хувааж, тэр ч байтугай технологийн уялдаа холбоог нь тасалдуулсны улмаас үйлдвэрлэсэн бүтээгдхүүнийх нь чанар урьдынхаасаа улам доройтож, гадаад зах зээл дээр өрсөлдөх чадваргүй болсон. Жишээлбэл, 1997 оны байдлаар Монголын 3500 стандартаас зөвхөн 5,6 хувь нь олон улсын хэм хэмжээний шаардлага хангаж байсан байна.<sup>8</sup>

Орос-Монголын улс төр, эдийн засгийн харилцааны хамгийн том тулгамдсан асуудал бол ЗСБНХУ-аас БНМАУ-ын авсан зээлийн өрийг шийдвэрлэх явдал юм. Үүнийг Монголын улс төрчид, судлаачид “их өрийн” асуудал гэж нэрлэдэг. БНМАУ, ЗХУ-аас их хэмжээний зээл хоёр чиглэлээр авсан түүхтэй.

Нэг дэх чиглэл нь барилга байгууламж бариулах зориулалтаар эдийн засаг, аж ахуй, соёлын бүхий л салбарт 2 хувийн хүүгэй хөрөнгө оруулалтын зээл авдаг байв. Ийм зээлийг хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түлш эрчим хүч, зам тээвэр, холбоо, барилга зэрэг үйлдвэрлэл, дэд бүтцийн салбар, мөн орон сууц, эмнэлэг, сургууль, шинжлэх ухааны зэрэг салбарт олон зуун том, жижиг барилга байгууламж барихад зориулан ашиглаж байлаа.

Хоёрдахь хэлбэрийн зээл бол Монгол-Зөвлөлтийн гадаад худалдааны экспорт, импортын барааны үнийн өсөлтийн зөрүүг нөхөхөд, өөрөөр хэлбэл, импортоос экспортын хэмжээ 1960 оноос хойш байнга дутуу байсан зөрүүг тэнцүүлэхэд зориулсан худалдааны зээл байсан юм.

Хөрөнгө оруулалтын зээлийн бүтцийг үйлдвэрлэл үйлчилгээний салбаруудаар тодорхойлбол: хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэлийн салбарт 18,4 хувь, түлш эрчим хүчний салбарт 20,5 хувь, тээвэр холбоо барилга, материал техникийн хангамж зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтцийн салбарт 18 хувь, орон сууц нийтийн аж ахуй, эрүүл мэнд ардын боловсрол зэрэг хүн амын нийгмийн үйлчилгээний хүрээнд 22 хувь, хөнгөн аж үйлдвэр, хамтарсан үйлдвэрүүд барьж байгуулахад 8 хувь, геологи хайгуул, зураг төслийн ажлыг сайжруулахад 5 хувь орчмыг тус тус зарцуулсан гэж Монголын тал үздэг. Хөрөнгө оруулалтын зориулалттай зээлийн дүнд сүрхий нөлөөлсөн нэгэн хүчин зүйл бол машин механизм тоног төхөөрөмж, барилгын материалын гадаад худалдааны үнэ өндөр болсон явдал байлаа.

БНМАУ-ын ЗХУ-аас авсан нийт зээлийн хэмжээ нь хоёр улсын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрийн дагуу 1990 оны 1-р сарын 1-ний өдрийн байдлаар 10 тэрбум шилжих рубль болсон гэж үзэж байлаа. Гэвч дараахи жилүүдэд хүүг бодолцоод 12,2 тэрбум долл. гэсэн тоо яригдаж эхэлсэн. Монголын тал бас 10,2 тэрбум гэсэн тоо гаргасан удаатай. “Их өрийн” асуудал нэн төвөгтэй гэдэг нь ойлгомжтой, түүнийг даруй шийдэх нь чухал юм. Монголын нийгэмд энэ асуудлаар олон санал байдаг. Тухайлбал, уул өр төлбөрийн талаар 1990 оны эхэн үед гол төлөв сэтгэл хөдлөл, хийсвэр таамаглалд автагдсан, мэргэжлийн бус хүмүүсийн дэгдээсэн туйлширсан хандлага байсан юм. Тэд нар хэлэхдээ, Монголд Улс ОХУ-д өргүй, харин авлагатай, нэгэнт алга болсон хоёр улсын хооронд үүссэн өрийг одоогийн Монгол Улс төлөх үндэс алга гэж байсан.

Харин 1980-аад оны сүүлийн хагаст Монголын Засгийн газар, эдийн засгийн төв байгууллагад алба хашиж тухайн байдлыг сайтар мэддэг байсан хүмүүс нь Монголын зээл, өрийн асуудлаар хоёр улсын хооронд албан ёсны түвшинд яриа хэлцэл идэвхтэй хийж, түүнийг нааштай шийдвэрлэх алхмууд хийж байжээ. Тэд нар Монголын өрийг хүчингүй болгох буюу эсвэл мэдэгдэхүйц багасгах талаар санал тавихдаа дараахи үндэслэлийг гаргаж байсан юм. Тухайлбал, буурай хөгжилтэй орны хүн ам, нийгмийн үйлчилгээний хүрээний болон дэд

бүтцийн салбарт зээл биш буцалтгүй тусламж олгодог дэлхий нийтийн олон улсын практикт байдаг зарчмыг харгалзан үзэж орон сууц, нийтийн аж ахуйн барилга байгууламж, эмнэлэг сургууль болон тээвэр холбоо, худалдаа хангамж, түлш-эрчим хүч, барилгын салбарт авсан зээлийг төлбөрөөс чөлөөлүүлэх санал тавьсан юм. Тэгэхдээ эдгээр салбарын зарим нь бүтээгдэхүүн бий болгож ашиг олдоггүй экспортын бүтээгдэхүүн, улмаар төлбөрийг бүрэлдүүлэн бүтээдэггүй, харин улс орны дотор хүн ам, үйлдвэрлэлд үйлчилдэг гэдгийг иш үндэс болгон тэдгээрт авсан 4 тэрбум рублийн зээлийг чөлөөлүүлэх санал хүсэлтээ тавьж байсан билээ.

Хөдөө аж ахуй, хүнсний аж үйлдвэрийн салбарт хөдөө аж ахуйн материал техникийн баазыг бэхжүүлэх, хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр авсан зээлийн төлбөр, 1,2 тэрбум рубль болж байсан. Гагцхүү эдгээр салбараас ЗХУ-д мал, мах, ноос, ноолуур арьс шир зэрэг малын гаралтай бүтээгдэхүүнийг олон арван жилийн турш маш хямд үнээр экспортлож байсан ба түүнээс Зөвлөлт “үнийн хайчаар” дамжуулан бага биш ашиг олж байсан тул үүнийг бас хасуулах санал тавьж байв.

Өнгөрсөн хугацаанд уул асуудлыг 1986 оноос эхэлж мэргэжлийн байгууллагуудын хэмжээнд ярилцаж байсан бол 2002 оноос хоёр улсын Засгийн газрын тэргүүнүүдийн хэмжээнд яригдаж, энэ асуудлаар хоёр тал харилцан ашигтай тохиролцоонд хүрэх хүсэлтэй байгаагаар албан ёсоор илэрхийлсэн билээ. Энэ нь Монголын Засгийн газар уул асуудлын талаар гарсан янз бүрийн туйлшрал, ялангуяа “Монголчууд Орост огт өргүй” гэх, ЗХУ Монголын хөгжилд туслалцаа үзүүлээгүй, харин дарамт үзүүлсэн гэсэн байр суурь ор үндэсгүй гэдгийг дэлхий нийтэд харуулсан үйл явдал юм. ЗХУ, ОХУ-ын төрийн тэргүүнүүд, тухайлбал М.Горбачев, Б.Ельцин, В.Путин нар цөмөөрөө Монгол Улсын эдийн засаг, ард түмний амьжиргаанд дарамт үзүүлж бэрхшээл учруулахгүйгээр өрийн асуудлыг шийднэ хэмээн удаа дараалан мэдэгдсээр ирсэн нь олон улсын уламжлалт харьцаатай, эх гүрнээс өөрийн хөрш, бага буурай оронд хандаж байдаг гадаад бодлогын хөдлөшгүй байр суурь мөн билээ.

2002 оны 3-дугаар сарын эцсээр ОХУ-ын Засгийн газрын дарга М.Касьянов Монголд айлчлах үеэр Монголын тал “их өрийг” шийдэх асуудалд хэрхэн хандах зарчмын талаархи байр сууриа тодорхойлон танилцуулсан юм. Уул байр суурь нь гэвэл:

- Уул өр үүссэн түүхэн нөхцөл байдлыг харгалзан үзэх



- Монголын эдийн засагт дарамт үзүүлэхгүй байх
- Ядуу буурай орнуудын өрийн асуудлыг шийдвэрлэдэг олон улсын туршлага, механизмыг харгалзан үзэх, хоёр орны цаашдын хамтын ажиллагааны тааламжтай нөхцөл бүрдүүлэх,
- Хамтарсан хөрөнгө оруулалт хийж, томоохон төсөл хэрэгжүүлэх замаар Монголын эдийн засгийн чадавхийг дээшлүүлж экспортын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг цогцолбор асуудлыг харгалзан үзэж шийдвэрлэхийг санал болгосонд оршиж байгаа юм.

“Их өр”-ийг төлөх тоо хэмжээний хувьд гэвэл хэлэлцээрийн дунд үе шатанд ОХУ 80-85%-ийг нь цайруулах санал тавьсныг нь Монголын тал хүлээж аваагүй ажээ. Монголын өндөр албаны хүмүүсийн мэдээлснээр 90-95%-ийг нь хүчингүй болгох санал гаргасан.<sup>9</sup>

2003 оны 7-р сард Монгол Улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр ОХУ-д айлчилсан нь уг асуудлыг нэг тийш болгоход томоохон алхам болсон юм. Монгол Улсын Ерөнхий сайдын энэ удаагийн айлчлалын үеэр олон баримт бичигт гарын үсэг зурсан нь хоёр орны хооронд хуримтлагдсан асуудлуудыг багцаар нь авч хэлэлцэн шийдвэрлэх зорилт тавьж ажилласантай холбоотой аж. Энэхүү айлчлалын үеэр хэлэлцсэн өөр нэг чухал асуудал бол Монгол-Оросын хамтарсан “Эрдэнэт” комбинатын тухай, энэ талаар байгуулаад хугацаа нь дууссан гэрээ, дүрмийн асуудал байсан юм. “Эрдэнэт” үйлдвэрт хамтран ажиллах тухай хэлэлцээрийг Монгол Улсын Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Оросын шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн дэд сайд С.Г.Митин нар үзэглэлээ. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэр, “Монголросцветмет”-ийг барьж байгуулахад зориулж Монгол Улсын авсан зээлийг хүчингүй болгосон нь энэ айлчлалын нэг үр дүн боллоо. Энэ үйлдвэр дэх хөрөнгийн Монголын талын 51 хувь, Оросын 49 хувийн харьцаа хэвээр үлдэв. Ингэснээр Улаанбаатар хотод байгаа, ОХУ-ын хөрөнгөөр барьсан 20 гаруй мянган ам.метр талбай бүхий орон сууцлыг Монголын талд бэлэг болгон өгч, уг суудуудыг тэнд амьдарч буй монгол, орос иргэдэд үнэгүй хувьчилж өгөх болсон. Хөрөнгө оруулахад нь зориулж Монгол Улсад зээл олгоход бэлэн байгаагаа ОХУ нотоллоо. Урьд нь тохирсон зарчмаа баримталж, Орос-Монголын хооронд тогтсон онцгой харилцааг харгалзан “стандарт бус” буюу огт өөр арга хэлбэрээр “их өр”-ийг хоёр улс бие даан шийдвэрлэх нь зүйтэй хэмээн тохиролцлоо<sup>10</sup>. Энэ арга нь уул асуудлыг шийдвэрлэхдээ

олон улсын практикт уламжлал болсон /Парисын клубийн гэх мэт/ аргыг голлон хэрэглэхгүй. Их өрийн асуудлыг шийдвэрлэх үндсэн нөхцлүүдийн талаар харилцан тохиролцоонд амжилттай хүрсэн гэж Монголын тал үзэж байна. Мөн Монгол Улсаас ОХУ-д суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.Баярын мэдээлснээр "...хэдий хэмжээний мөнгийг ямар нөхцлөөр төлөх вэ гэдгээс хамаараад төлөх өрийн хэмжээ улам ч багасах магадлалтай..."<sup>11</sup>. Мөн энэ айлчлалын дүнгээр гаргасан Хамтарсан албан мэдээнд "сайн хөршийн уламжлалт түншлэл" гэсэн томъёоллыг хоёр орны харилцааны тухайд анх удаа хэрэглэж, дээд хэмжээний бичигт тусгасан нь шинэлэг зүйл болсон юм. Удахгүй ОХУ-ын ГХЯ-ны сайд И.Иванов Монгол Улсад албан ёсны айлчлал хийх гэж байгаа нь хоёр орны харилцааг улам өндөр түвшинд гаргах болно. Ирэх онд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди ОХУ-д албан ёсны айлчлал хийхийг хоёр тал тохирсон бөгөөд энэ айлчлалын үеэр хоёр орны хооронд хуримтлагдсан ээдрээтэй асуудлууд шийдлээ олох нь эргэлзээгүй.

"Эрдэнэт" комбинат бол Монголын эдийн засгийн хямралд ороод байсан бэрхшээлтэй үед хамаг хүнд ачааг үүрч "локомотивын" үүрэг гүйцэтгэсэн төдийгүй одоо ч онц чухал ач холбогдолтой хэвээр байна. Эцсийн дүнд "их өрийг" ямар нэг хэмжээгээр цайруулсны дараа үлдэх хэсгийг төлөх асуудал "Эрдэнэт" комбинат, "Монголросцветмет", "УБТЗ" гэсэн Оросын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэр, аж ахуйн газрын цаашдын үйл ажиллагааг яаж үр ашигтай, өгөөж сайтай болгох вэ гэдгээс шууд хамаарах бололтой.

Хэгийн стратеги зорилгын үүднээс авч үзвэл ОХУ эдийн засгийн байр сууриа Монголд эдүгээ алдаад байгаа бодит үнэнийг анхааралдаа авч цаашдаа эдийн засгийн томоохон шинэ сонирхол буй болгож Зүүн хойд Ази болон бусад зах зээл дээр "ноёрхох" байр суурьтай болгоход чиглэсэн төсөл боловсруулж хэрэгжүүлэх нь нэн чухал юм.

ОХУ сүүлийн 10 гаруй жилийн дотор эдийн засгийн хувьд нөлөө үзүүлэхүйц нэг ч шинэ үйлдвэрийн газар байгуулаагүй байгаа нь түүний геополитикийн зорилт болон их гүрний байр суурьтай нь харьцуулахад чамлалттай үзүүлэлт гэж би хувьдаа үзэж байна.

Одоогийн байдлаар Монголын зах зээл хямд бөгөөд чанар муутай Хятадын аж үйлдвэр, хүнсний бараагаар дүүрч улмаар БНХАУ-ын түүхий эдийн хэрэгцээг хангадаг нэг "хавсарга" болоод байгаа үед, юуны өмнө, Алтанбулагийн эдийн засгийн чөлөөт бүсийг эрчимтэй хөгжүүлэхэд идэвхтэй оролцож, Орос-Монголын хамтарсан



үйлдвэрүүдийн тоог нэмж, Монголын ард түмний сайшаалыг хүлээсэн Оросын үйлдвэрлэлийн бараа бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх замаар Хятадын Эрээн хоттой өрсөлдөх нь хоёр талаас хэрэгжүүлбэл зохих анхны бодит алхам мөн болов уу.

Гэвч Орос-Монголын улс төрийн харилцаанаас эдийн засгийн харилцаа мэдэгдэхүйц хоцорч байгаа нь илэрхий боловч, түүнийг өөрчлөн шийдвэрлэж чадахгүй хойшлуулсаар ирсэн байна. Үүнээс ихээхэн шалтгаалж ОХУ 1990 оноос хойшхи жилүүдэд, ө.х. 1990-2001 онуудад Монголын экспортод, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тоонд болон оруулсан хөрөнгийнхөө нийт хэмжээгээр БНХАУ, Япон, БНСУ, АНУ-аас хоцорч явсан. Үүнээс ОХУ зохих дүгнэлт хийж Монгол Улсад стратегийн ач холбогдолтой эдийн засгийн томоохон сонирхолтой болгох чиглэлээр хоёр орны хамтын ажиллагааны тодорхой бодлого, төсөл боловсруулж хэрэгжүүлэх нь чухал байна. Энэ нь Монголын экспортыг өсгөж төлбөрийн чадварыг нэмэгдүүлэх болно. Үүний зэрэгцээ юуны түрүүнд Орос-Монголын хамтарсан “Эрдэнэт” комбинат, “Монголросцветмет”, “УБТЗ” зэрэг хоёр орны эдийн засгийн харилцаанд чухал үүрэг гүйцэтгэдэг үйлдвэр, аж ахуйн газруудын эдийн засгийн үр ашиг цаашид буурах хандлагатай байгаа тул тэдгээрт ОХУ-аас дахин хөрөнгө оруулж техник, технологийн хувьд ойрын үед шинэчлэх асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.

Ялангуяа хамтарсан “Эрдэнэт” комбинатын тухай ярьсаар ирсэн зэсийн баяжмалыг гүнзгийрүүлэн боловсруулж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх асуудлыг нэг мөр болгож шийдвэрлэвэл эдийн засгийн үр ашиг, экспортын потенциал эрс нэмэгдэх талтай.

Орос-Монголын эдийн засгийн харилцааны хамгийн эмзэг төвөгтэй асуудал болсон “их өр”-ийн адил бас нэг байнгын “бага өр” буй болгохгүйн тулд Монголоос ОХУ-д өгвөл зохих урсгал өрийг төлөх арга замыг олох, тухайлбал, хивс, ноосон бараа, сүлжмэл эдлэл, арьс ширэн бүтээгдэхүүн, нэхий эдлэлээр төлөх тухай Монголын талаас олон жил дараалан тавьсан хүсэлтийг хүлээж авбал хоёр орны худалдааны эргэлт мэдэгдэхүйц нэмэгдэх болно. Үүний зэрэгцээ олон жил яригдсаар ирсэн Монголын экспортын бараанд ОХУ-ын талаас тогтоосон гаалийн татварыг багасгах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.

Зөвхөн эдийн засгийн бус, мөн хил орчим, соёлын чиглэлүүдээр холбогдох арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлбэл Орос-Монголын харилцаа цаашид улам өргөжин хөгжих болно.

**ИШЛЭЛ ЗҮҮЛТ**

1. Выступление Б.Ельцина в Верховном Совете РФ. М., 1992
2. Абазов Р. "Политика России в АТР: смена парадигм", "Международная экономика и международные отношения". №2, 1997
3. Путин В. "Оросын гадаад бодлогын тэргүүлэх чиглэлд танай орон онцгой байр суурь эзэлдэг". "Зууны мэдээ". 2000.11.15. №268/535.
4. "Гадаад орнуудтай соёлын талаар харилцах харилцааг өргөжүүлэх ОХУ-ын ГЯЯ-ны үйл ажиллагааны үндсэн чиглэлүүд". М., 2001.
5. Выступление Президента РФ В.В.Путина в Министерстве иностранных дел РФ. 26 января 2001. Москва.
6. Монгол Улсын Статистикийн эмхэтгэл, 1992-2002 оны мэдээлэл.
7. Гадаадын хөрөнгө оруулалтын газрын мэдээ. 1990-2001 он.
8. Яскина Г. "Прагматизм - основа обновления отношений", "Азия и Африка". №6, 2002
9. Улаан Ч. "Мы стремимся, чтобы российская аннулировала, если удастся 95%, если нет, то 90% большого долга". "Монголия сегодня", 15.03.2003
10. "Өрийн асуудлыг зохицуулах Меморандумд гарын үсэг зурлаа". №156 /1894/ 07.03.
11. С.Баяр "ОХУ-д төлөх өрийн хэмжээ улам ч багасах магадлал бий". "Өнөөдөр", 2003.10.15. №241 /1979/.